



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 1 сарын 19 өдөр

Дугаар А/5

Улаанбаатар хот


Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл,
удирдлагын нэгдсэн системийн батлагдсан төсөвт
өртгийг хуваарилан зарцуулах тухай

“Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.1.4-ийн 5 дахь заалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно” гэж тусгасан, Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 6.1 дугаарт батлагдсан 1,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгт “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлагын нэгдсэн систем” / УТ2401000272/ код бүхий төсөл хөтөлбөрийг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу үйлчилгээ авах тендер болон бараа худалдан авах тендер болгон хавсралтад заасны дагуу хувааж тендер зохион байгуулах болон шалгаруулах ажилд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 6.1 дугаарт батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлагын нэгдсэн систем” төслийн энэ онд батлагдсан 1,2 тэрбум төгрөгийг энэхүү тушаалын хавсралтын дагуу хуваариар баталж төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр олгохыг Захиргаа удирдлагын хэлтэс (Д.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013847